



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Сайнцагаан сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2025/64/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Дундговь аймаг
2025 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ
Утас: 70592225
Цахим хаяг: Oyunerdenet@audit.gov.mn

Ахлах аудитор: Т.Батсайхан
Утас: 70593113
Цахим хаяг: Batsaikhan@audit.gov.mn

Аудитор: Л.Уранбилэг
Утас: 70593208
Цахим хаяг: Uranbilegl@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга	
2.1 Аудит хийсэн санхүү байдлын тайлан тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН	8

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын эрхлэл, 7-р баг, Сайншалан сууц
Дундговь аймаг 43090 Утас: 70592439, 70592208,
70595208, Цахын хаяг: dundgovi@audit.gov.mn

2025.06.12 № 07

Төрийн _____ -ийн № _____

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Сайнцагаан сумын 3-р цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйцэтгэлийн тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Сайнцагаан сумын 3-р цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийг хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторуудын багшлан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторууд 8с зүйн үүрэг хариуцлагыг биелүүж ажилласан. Бүхний цуглуулсан хяналттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2024 оны 04 сарын сарын 01-ээр төрийн албын хаагчийн үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 234.5 сая төгрөгөөр өссөн байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулашгүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Тайлант үсний санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналал өндөр үнэтэгдсэн эрдэл, ногоо бүхий эрдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байхгүй.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хяналттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн тоололгоонд 5 зорилт, 52 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, сумын Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 99.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

2025061206

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүү байдлын тайлан тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	308,474,570.73	392,213,766.94
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	82,257,332.51	149,710,692.44
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	82,257,332.51	149,710,692.44
3121	Төгрөг	82,257,332.51	149,710,692.44
31211	Төрийн сангийн харилцах	64,289,358.77	128,550,648.70
31218	Ахмадын сангийн харилцах	17,967,973.74	21,160,043.74
35	БАРАА МАТЕРИАЛ	226,217,238.22	242,503,074.50
351	Түүхий эд материал	182,824,686.52	191,001,845.00
35110	Тусгай зориулалттай материал	181,767,266.52	189,989,425.00
35130	Эм боох материал	1,057,420.00	1,012,420.00
354	Хангамжийн материал	43,392,551.70	51,501,229.50
35410	Бичиг хэргийн материал	3,804,200.00	4,679,200.00
35420	Аж ахуйн материал	22,605,497.00	30,257,325.50
35450	Барилгын засварын материал	360,000.00	-
35460	Хүнсний материал	16,622,854.70	16,564,704.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,061,921,408.03	1,045,157,433.43
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,061,921,408.03	1,045,157,433.43
39100	Газар		
392	Биет хөрөнгө	999,869,408.03	983,105,433.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,033,346,675.17	1,063,714,816.39
39202	Хуримтлагдсан элэгдэл	(147,926,104.33)	(193,468,341.21)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	90,782,950.00	104,181,950.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(23,612,242.20)	(31,172,933.89)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	64,536,600.00	62,114,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,258,470.61)	(22,264,057.86)
393	Биет бус хөрөнгө	62,052,000.00	62,052,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	62,052,000.00	62,052,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,370,395,978.76	1,437,371,200.37
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,370,395,978.76	1,437,371,200.37
51	Засгийн газрын хувь оролцоо	1,370,395,978.76	1,437,371,200.37
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	232,826,019.12	232,826,019.12
51101	Өмч: - төрийн	232,826,019.12	232,826,019.12
512	Хуримтлагдсан үр дүн	681,248,830.09	748,643,133.48
51210	Өмнөх үеийн үр дүн	381,295,988.79	681,667,911.87
51220	Тайлант үеийн үр дүн	299,952,841.30	66,975,221.61
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	456,321,129.55	455,902,047.77
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,370,395,978.76	1,437,371,200.37

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

11	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,116,726,965.00	1,192,081,989.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	309,998,765.00	96,678,625.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,948,000.00	15,721,342.40
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	151,800,217.00	46,637,223.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	142,250,548.00	34,320,060.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	806,728,200.00	1,095,403,364.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	711,999,200.00	1,028,366,364.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	711,999,200.00	1,028,366,364.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	550,000.00	-

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	550,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	60,844,000.00	67,037,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	60,844,000.00	67,037,000.00
1330	Төсвийн захирагчдаас	33,335,000.00	-
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	33,335,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	811,302,501.80	1,124,777,232.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	811,302,501.80	1,124,777,232.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	796,687,067.46	1,109,506,219.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	487,241,031.95	721,781,151.00
210101	Үндсэн цалин	330,586,243.95	452,248,045.00
210102	Нэмэгдэл	124,048,831.00	175,789,340.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,600,000.00	54,500,000.00
210104	Урамшуулал	22,005,957.00	39,243,766.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,415,541.99	86,923,632.47
210201	Тэтгэврийн даатгал	41,807,548.85	61,164,876.47
210202	Тэтгэмжийн даатгал	4,918,531.98	7,159,625.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,767,621.99	3,473,937.00
210204	Ажилгүйдлийн даатгал	892,970.20	3,037,252.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,028,868.97	12,087,942.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,291,305.66	63,015,997.02
210301	Гэрэл, цахилгаан	7,986,681.66	9,118,018.02
210302	Түлш, халаалт	42,260,000.00	46,940,905.00
210303	Цэвэр, бохир ус	6,044,624.00	6,957,074.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,374,800.20	39,562,131.02
210401	Бичиг хэрэг	10,663,750.00	13,233,060.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,590,560.00	22,148,209.50
210408	Бараа материал акталсны зардал	1,120,490.20	4,180,861.52
2105	Нормативт зардал	86,307,063.14	103,078,625.70
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	293,048.00	315,000.00
210502	Хоол, хүнс	86,014,015.14	102,763,625.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,551,960.00	4,380,990.00
210604	Урсгал засвар	4,551,960.00	4,380,990.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,493,300.00	2,223,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,493,300.00	2,223,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	76,012,064.52	88,539,892.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,419,360.00	12,318,930.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,613,990.00	3,939,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	64,978,714.52	72,281,662.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,615,434.34	15,271,012.98
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,614,700.00	15,271,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,614,700.00	15,271,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	734.34	12.98
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	734.34	12.98
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	305,424,463.20	67,304,756.63
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,471,637.90	329,535.02
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	54,087.90	329,535.02
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	5,417,550.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(5,471,637.90)	(329,535.02)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	299,952,825.30	66,975,221.61

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	822,676,200.00	1,111,124,706.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	15,721,342.40
120	Нийтлэг татварын бус орлого	-	15,721,342.40
120,004.00	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	15,721,342.40
1,200,042.00	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	15,721,342.40
1,200,047.00	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	15,948,000.00	-
13.00	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	806,728,200.00	1,095,403,364.00
1,310.00	Улсын төвлөрсөн төсвөөс	711,999,200.00	1,028,366,364.00
131,001.00	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	711,999,200.00	1,028,366,364.00
1,311.00	Нэмэлт санхүүжилтийн орлого	550,000.00	-
131,104.00	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	550,000.00	-
1,320.00	Орон нутгийн төсвөөс санхүүжих	60,844,000.00	67,037,000.00
132,001.00	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	60,844,000.00	67,037,000.00
1,330.00	Төсвийн захирагчдаас	33,335,000.00	-
133,001.00	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	33,335,000.00	-
2.00	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	737,590,358.94	1,034,461,346.47
21.00	УРСГАЛ ЗАРДАЛ	737,590,358.94	1,034,461,346.47
210.00	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	722,974,924.60	1,019,190,333.49
2,101.00	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	487,241,031.95	721,781,151.00
210,101.00	Үндсэн цалин	330,586,243.95	452,248,045.00
210,102.00	Нэмэгдэл	124,048,831.00	175,789,340.00
210,103.00	Унаа хоолны хөнгөлөлт	10,600,000.00	54,500,000.00
210,104.00	Урамшуулал	22,005,957.00	39,243,766.00
2,102.00	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,415,541.99	86,923,632.47
210,201.00	Тэтгэврийн даатгал	41,807,548.85	61,164,876.47
210,202.00	Тэтгэмжийн даатгал	4,918,531.98	7,159,625.00
210,203.00	ҮОМШӨ-ний даатгал	3,767,621.99	3,473,937.00
210,204.00	Ажилгүйдлийн даатгал	892,970.20	3,037,252.00
210,205.00	Эрүүл мэндийн даатгал	9,028,868.97	12,087,942.00
2,103.00	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,291,305.66	63,015,997.02
210,301.00	Гэрэл, цахилгаан	7,986,681.66	9,118,018.02
210,302.00	Түлш, халаалт	42,260,000.00	46,940,905.00
210,303.00	Цэвэр, бохир ус	6,044,624.00	6,957,074.00
2,105.00	Нормативт зардал	89,105,130.00	98,424,715.00
210,502.00	Хоол, хүнс	89,105,130.00	98,424,715.00
2,106.00	Эд хогшил, урсгал засварын зардал	4,551,960.00	4,020,990.00
210,604.00	Урсгал засвар	4,551,960.00	4,020,990.00
2,108.00	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,493,300.00	3,375,800.00
210,806.00	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,493,300.00	3,375,800.00
2,109.00	Бараа үйлчилгээний бусад зардал	23,876,655.00	41,648,048.00
210,901.00	Бараа үйлчилгээний бусад зардал	19,379,860.00	31,359,448.00
210,902.00	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,496,795.00	10,288,600.00
213.00	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,615,434.34	15,271,012.98
2,132.00	Бусад урсгал шилжүүлэг	14,614,700.00	15,271,000.00
213,209.00	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,614,700.00	15,271,000.00
2,134.00	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	734.34	12.98
213,403.00	Төвлөрүүлэх шилжүүлэг	734.34	12.98
3.00	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	69,137,841.06	76,663,359.93
5.00	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5.00	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,830,000.00	9,210,000.00
22.00	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,830,000.00	9,210,000.00
2,200.00	Дотоод эх үүсвэрээр	9,830,000.00	9,210,000.00

225,106.00	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,830,000.00	9,210,000.00
2,260.00	Гадаад эх үүсвэрээр	-	-
6.00	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(9,830,000.00)	(9,210,000.00)
8.00	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	75,255,841.06	67,453,359.93
9.00	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7,001,475.45	82,257,332.51
10.00	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	82,257,316.51	149,710,692.44

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	232,826,019.12	457,406,491.01	435,710,627.33	1,125,943,137.46
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(54,414,638.54)	(54,414,638.54)
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	232,826,019.12	457,406,491.01	381,295,988.79	1,071,528,498.92
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(1,085,361.46)	-	(1,085,361.46)
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	299,952,841.30	299,952,841.30
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	232,826,019.12	456,321,129.55	681,248,830.09	1,370,395,978.76
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	232,826,019.12	456,321,129.55	681,248,830.09	1,370,395,978.76
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	419,081.78	419,081.78
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	232,826,019.12	456,321,129.55	681,667,911.87	1,370,815,060.54
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(419,081.78)	-	(419,081.78)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	66,975,221.61	66,975,221.61
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	232,826,019.12	455,902,047.77	748,643,133.48	1,437,371,200.37

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		82,257,332.57
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,165,454,600.00	1,043,526,782.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,165,454,600.00	1,043,526,782.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,150,183,600.00	1,028,255,769.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	832,754,500.00	721,636,587.00
210101	Үндсэн цалин	599,948,700.00	452,248,045.00
210102	Нэмэгдэл	218,546,200.00	175,644,776.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	54,500,000.00
210104	Урамшуулал	14,259,600.00	39,243,766.00
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,582,000.00	86,923,632.47

210201	Тэтгэврийн даатгал	64,997,900.00	61,164,876.47
210202	Тэтгэмжийн даатгал	7,644,400.00	7,159,625.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,823,200.00	3,473,937.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,823,200.00	3,037,252.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,293,300.00	12,087,942.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,016,000.00	63,015,997.02
210301	Гэрэл, цахилгаан	9,118,000.00	9,118,018.02
210302	Түлш, халаалт	46,940,900.00	46,940,905.00
210303	Цэвэр, бохир ус	6,957,100.00	6,957,074.00
2105	Нормативт зардал	101,492,400.00	98,424,715.00
210502	Хоол, хүнс	101,492,400.00	98,424,715.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,021,000.00	4,020,990.00
210604	Урсгал засвар	4,021,000.00	4,020,990.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,563,900.00	3,375,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,563,900.00	3,375,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,753,800.00	50,858,048.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,464,500.00	40,569,448.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,289,300.00	10,288,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,271,000.00	15,271,012.98
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,271,000.00	15,271,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,271,000.00	15,271,000.00
26	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	12.98
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	12.98
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,165,454,600.00	1,110,980,142.40
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,028,409,800.00	1,028,221,800.00
122005	Улсын төсвөөс санхүүжих	1,028,409,800.00	1,028,221,800.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	67,037,000.00	67,037,000.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	70,007,800.00	15,721,342.40
120010	Туслах үйл ажиллагааны орлого	5,721,400.00	15,721,342.40
120004 3	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	64,286,400.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	64,289,358.77
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	149,710,692.44

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” заасны дагуу Дундговь аймгийн Сайнцагаан сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төрийн аудитын аудитор Л.Уранбилэг гүйцэтгэж, чанарын хяналтыг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Т.Оюун-Эрдэнэ, газрын дарга, Тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Сайнцагаан сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 09 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг санхүү, үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,124,777.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 11,247.7 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн үе шатанд материаллаг түвшнийг шинэчлэн тогтоогүй болно.

3.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор батлагдсан төсвийн 92.0 хувийг зарцуулж, 149,710.7 мянган төгрөгийн дансны үлдэгдэлтэй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллагад 29 арга хэмжээг түүвэрлэн шалгахаар төлөвлөн хэрэгжүүллээ.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой төлөвлөсөн горим сорилыг гүйцэтгэхэд алдаа, зөрчил илрээгүй.

3.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

3.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 4 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Сайнцагаан сумын 3 дугаар цэцэрлэг нь 2024 онд нийт 1,098,710.6 мянган төгрөгийн 83 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, бүрэн байршуулахаас 83 мэдээллийг бүрэн байршуулж мэдээлсэн байна.

3.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

3.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

3.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант онд завсрын аудит хийгдээгүй.

3.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар цалингийн данстай холбоотой асуудалд 1 төлбөрийн акт, шилэн данстай холбоотой 1 зөвлөмж, хууль тогтоомжтой холбоотой 1 зөвлөмж өгснийг 100 хувь хэрэгжүүлэн, хариуг ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	20.0	1	20.0	100
Зөвлөмж	2	0	2	0	100
Нийт дүн	3	20.0	3	20.0	100

3.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан нормативт зардлын зарцуулалтын тооцооллыг шалгах, үндсэн хөрөнгө тооллого хийж биет тест хэрэгжүүлэх горимыг дараагийн аудитаар хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,955.4 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 782.1 мянган төгрөгийн 1 хугацаатай албан шаардлага, 3,173.2 мянган төгрөгийн 1 заалт зөвлөмжийг тус тус хүргүүллээ.

4.1 Албан шаардлага

Аудитаар интернэтийн төлбөр **782.1** мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас төлж эдийн засгийн ангиллыг баримтлаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т /Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоолын 4- дүгээр хавсралтаар батлагдсан "Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх" журмын 8.5-д /Нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээнд үндэслэн олгосон санхүүжилтийг зориулалт, эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах үүрэгтэй/ мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт:

Байгууллагын удирдлага нь нягтлан бодогч, няравт нарт албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан, 2023 оны санхүүгийн тайланд зөрчилгүй санал дүгнэлт авсан гэх үндэслэлээр мөнгөн урамшууллыг давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т /Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-т /улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох/, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т /Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно/, 15.1.3-т /Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох/, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.3-т /мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид/ олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна. Мөн 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2-т /Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй мөн нийцсэн ба зохистой байх мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан арга хэмжээгээр давхардуулан урамшуулал олгохгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т заасан үр бүтээл гаргасан гэдгийг нотлох баримттай, тодорхой шалгуурыг хангасан тохиолдол урамшууллыг олгож хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Интернэтийн төлбөрийг бараа үйлчилгээний бусад зардлаас төлж эдийн засгийн ангилал зөрчсөн	1	782.1			1	782.1						
Байгууллагын удирлага нягтлан бодогч, няравт нарт 2023 оны санхүүгийн тайланд зөрчилгүй санал дүгнэлт авсан гэх үндэслэлээр үр дүнгийн урамшууллыг давхардуулан тооцож олгосон	1	3,173.2					1	3,173.2				
Дүн	2	3,955.3			1	782.1	1	3,173.2				